



2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Архив, бичиг хэргийн эрхлэгч
М.Баярмаа

АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын Засаг даргын Тамгын газарт 2023 оны 06 дугаар сарын 05-ны байдлаар 172 албан бичиг ирсэн бөгөөд ер программаар болон бүртгэлийн дэвтрээр бүртгэл хөтөлж байна.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРЛАГААНЫ НЭГДСЭН СИСТЕМ

Албан бичиг > Ирсэн бичиг

Өөрийн харуулсан: 2023-01-01 - 2023-12-31

№	Дугаар	Огноо	Хаанаас	Төлөн утга	Гаднаад эсэх	Хариутай эсэх	Шийдвэрлэлт	Хариулагч	Бичиг хаах
171	A331	2023-05-31	Дундговь...	Урамшуулал олгох...	Үгүй	Үгүй	-	Б... Засаг даргын...	Хаагаагүй
170	01/800	2023-06-05	Дундговь...	Тайлан мэдээ	Үгүй	Хариу өгөөгүй	-	О Амгалантөр Найрмын	Хаах
169	01/799	2023-05-30	Дундговь...	Тайлан мэдээ	Үгүй	Хариу өгөөгүй	-	Б... Засаг даргын...	Хаах
168	01/817	2023-06-05	Дундговь...	Албан хараа-20...	Үгүй	Хариу өгөөгүй	-	Б... Засаг даргын...	Хаах
167	01/816	2023-06-05	Дундговь...	2023 оны хагас...	Үгүй	Хариу өгөөгүй	-	Б... Засаг даргын...	Хаах
166	01/319	2023-06-05	Дундговь...	Ундармаж хургууль...	Үгүй	Үгүй	-	О Амгалантөр Найрмын	-
165	02/815	2023-06-05	Дундговь...	Хүсэлт хургууль...	Үгүй	Хариу өгөөгүй	-	Б... Засаг даргын...	Хаах

Нийт 172 50/хуудас < 1 2 3 4 > Очих 1

Исэлтэй байла 882

11:12 PM 6/5/2023

- ✘ 172 бичгээс:
- ✘ Хугацаатай бичиг – 95
- ✘ Хугацаандаа шийдвэрлэж хаасан – 62
- ✘ Хугацаа хэтэрсэн-32 (хугацаандаа шийдвэрлэсэн боловч программ дээр шийдвэрлэлт хийгдээгүй), Алтанхүү-8, Баянмөнх-7, Амгаланжаргал-5, Уугандорж-5, Амгалантөр-2, Сумъяа-1, Мөнхбадрах-1, Сайхантуяа-1
- ✘ Хугацаа болоогүй-1

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМ

Албан бичиг > Ирсэн бичиг

Өөрийн хариуцсан 2023-01-01 - 2023-12-31

Нийт 172 Шинээр ирсэн 1 Судлагдаж байгаа 69 Шийдвэрлэсэн 62 Эргэн танилцах 4 Хугацаа дөхсөн 1 Хугацаа хэтэрсэн 32 Үйлдэл хянах 23 Буцаасан 0

	№	Дугаар	Огноо	Хаанаас	Товч утга	Гадаад эсэх	Хариутай эсэх	Шийдвэрлэлт	Хариуцагч	Бичиг хаах
	171	A/331	2023-05-31	Дундговь...	Урамшуулал олгох...	Үгүй	Үгүй	-	Б... Засаг даргын...	Хаагаагүй
	170	01/800	2023-06-05	Дундговь...	Тайлан мэдээ...	Үгүй	Хариу өгөөгүй	-	О Амгалантөр Нийгмийн...	Хаах
	169	01/799	2023-05-30	Дундговь...	Тайлан мэдээ...	Үгүй	Хариу өгөөгүй	-	Б... Засаг даргын...	Хаах
	168	01/817	2023-06-05	Дундговь...	Альсын хараа-20...	Үгүй	Хариу өгөөгүй	-	Б... Засаг даргын...	Хаах
	167	01/816	2023-06-05	Дундговь...	2023 оны хагас...	Үгүй	Хариу өгөөгүй	-	Б... Засаг даргын...	Хаах
	166	01/319	2023-06-05	Дундговь...	Удирдамж хүргүүлэ...	Үгүй	Үгүй	-	О Амгалантөр Нийгмийн...	-
	165	02/815	2023-06-05	Дундговь...	Хүсэлт хүргүүлэ...	Үгүй	Хариу өгөөгүй	-	Б... Засаг даргын...	Хаах

Нийт 172 50/хуудас < 1 2 3 4 > Очих 1

Идэвхтэй байгаа 882

11:12 PM 6/5/2023

-
- ✘ Засаг даргын Тамгын газраас бусад байгууллагатай харилцсан 140 албан бичгийг ер программаар бүртгэл хөтөлж илгээсэн.
 - ✘ Албан бичиг солилцооны дундын системд холбогдож, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хүрээнд тоон гарын үсэг эзэмшигч албан хаагчдын судалгааг хүргүүлсэн. (тоон гарын үсэг ирээгүй байгаа). Засаг дарга болон ЗДТГ-ын даргын хэвлэмэл хуудсыг АЕГ-т файлаар илгээж батлуулсан.

ERP программын и-токенийг холбож, албан бичгийг цахим гарын үсгээр илгээх бэлтгэл ажлыг 100 хувь хангасан. Мөн төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудсыг Төрийн архиваар хянуулж, Монгол бичгийн хэвлэмэл хуудсын загварыг батлуулж, туршилтын журмаар тус бүр 50 ширхэгийг хэвлүүлсэн.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн тайланг 1 дүгээр улирлад хуулийн хугацаанд нь Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсэн. (2 дугаар улирлын тайлангийн хугацаа болоогүй) Мөн 1 дүгээр улиралд Засаг даргаас батлан гаргасан 31 захирамж, ЗДТГ-ын даргаас батлан гаргасан 5 тушаалыг аймгийн Хууль эрхзүйн хэлтэст хянуулж, зөрчлийг арилгасан тухай албан бичгээр хүргүүлсэн. (2 дугаар улирлын эрхзүйн акт хянуулах хугацаа 6 дугаар сарын 19-ний дотор)

-
- ✘ Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээллийг 5 удаа хугацаанд нь оруулсан. Дундговь сайтад эрхзүйн баримт бичгүүд (67 захирамж, 2 тушаал)-ыг тухай бүрт оруулж байна.
 - ✘ И-Монголиа сайтаас иргэнд 14 лавлагаа олгож, иргэдэд хэрхэн лавлагаа авах талаар арга зүйн заавар зөвлөгөө өгч ажилласан.

ХОЁР. АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны баримтыг ХХНЖ-ийн дагуу байгууллагын архивт хүлээн авч, 2022 оны байнга хадгалах 22, түр хадгалах 51, 70 жил хадгалах 9, устгах 116 хадгаламжийн нэгжийн бүртгэлийг хийж, байгууллагын баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

2022 оны А, Б захирамж, А, Б тушаалыг цахимжуулж, цахим архивын сан үүсгэсэн. Ирсэн бичиг, явсан бичиг, Өргөдөл, гомдол, санал хүсэлт шийдвэрлэлтийн тайлан, Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ, гэрээний хэрэгжилт, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн мал тооллогын А данс зэрэг 21 хадгаламжийн нэгжийг стандартын дагуу архивын нэгж үүсгэсэн.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох 5 иргэнд мал тооллогын А дансны лавлагаа болон төсөвт байгууллагын 1990-2004 оны цалингийн лавлагаа, 3 иргэнд Энхтайван нэгдлийн 1983-1992 оны цалин хөлсний лавлагаа олгосон.

Цахим Дундговь албан хэрэг хөтлөлтийн 4 цагийн сургалт, И-монголиа оперторын шинэчилсэн сургалт, Гурвансайхан суманд зохион байгуулагдсан Зүүн бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөнөөр зохион байгуулагдсан сургалтуудад хамрагдсан.